



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР**

Хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн МЭДЭЭЛЭЛ

2022 оны 9 дугаар сарын байдлаар

Мөрөн сум

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

ТӨРӨЛТ

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 9 сарын байдлаар 1696 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 311 тохиолдол буюу 15.5%-иар буурсан байна. Төрөлт Бүрэнтогтох, Галт, Жаргалант, Их-Уул, Түнэл, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган сумдад өсч бусад сумдад өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Нийт төрсөн эхчүүдээс 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан хамрагдалтын хувь 69.0% байна.




ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 9 сарын байдлаар нийт 1706 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 307 тохиолдолоор буурсан байна. Амьд төрсөн хүүхдийн 3,6 хувь /64/ нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төрсөн байна. Төрөөд нэг цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 96,4 хувь байна. 5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтанд 2022 оны эхний 9 сард нийт 42658 хүүхэд жинлэж, жинлэсэн хүүхдийн 0.1 хувь нь туранхай, 0,1 хувь нь тураалтай, 0,1 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна. 27.6 хувь нь А амин дэм, 60.6 хувь нь Д амин дэм, 7.6 хувь нь олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн байна.

НЯЛХАСЫН ЭНДЭГДЭЛ


Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 9 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 26 тохиолдол бүртгэгдсэн нь 2021 оны мөн үеэс 3 тохиолдлоор буурч, 1000 амьд төрөлтөнд 15.2 ногдож байна. Нялхсын эндэгдлийн 50.0 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа бөгөөд 1000 амьд төрөлтөд 7.6 байна. Нийт 18 тохиолдол буюу 69.2 хувь нь эмнэлэгт эндсэн бөгөөд 15 нь эрэгтэй хүүхэд байна.

Нялхсын эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл:



1-5 НАС ХҮРТЭЛХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

2022 оны эхний 9 сарын байдлаар 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 6 тохиолдлоор буурсан байна. 1000 амьд төрөлтөнд 2.3 ногдож байна. Хүүхдийн эндэгдлийг оношоор нь авч үзвэл дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны эмгэг 1, амьсгалын тогтолцооны эмгэг 1, осол гэмтлийн шалтгаант нас баралтын 2 тохиолдол бүртгэгдсэн байна.



НАС БАРАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ


2022 оны эхний 9 сарын байдлаар 580 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 18 тохиолдолоор өссөн байна. Нийт нас баралтын 20,5 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс 29,4 хувь нь хоног болоогүй нас баралт байна. Осол гэмтлийн нас баралт 100 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 27 тохиолдолоор өссөн, нийт нас баралтын 17,2 хувийг эзэлж, 10000 хүн амд 7.3 ногдож байна. Хорт хавдрын нас баралт 144 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 9 тохиолдлоор өсч, нийт нас баралтын 24,8 хувийг эзэлж, 10000 хүн амд 10,5 ногдож байна.



Нийт нас баралтын тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 15,4
2. Хавдар-10,5
3. Гадны шалтгаант өвчлөл- 7,3
4. Амьсгалын тогтолцооны өвчин-2,6
5. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг-2.3

Осол гэмтлийн шалтгаант нас баралт,
2022 оны эхний 9 сарын байдлаар




Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 9 сарын байдлаар нийт эдийн шинжилгээ 773, эсийн шинжилгээ 3203 хийгдсэн байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 84 нас баралт буюу 48,8% эмгэг судлалын задлан шинжилгээ хийгдэж үндсэн оношийн зөрүү 2 бүртгэгдсэн байна. Задлан шинжилгээ хийгдээгүй нас баралт 43 тохиолдол байна.


АМБУЛАТОРИ СТАЦИОНАРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 9 сарын байдлаар амбулаторид нийт 338930 үзлэг хийгдсэнээс 26.0 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 57.1 хувийг өвчний учир амбулаторид, 9.9 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 4.5 хувийг гэрийн идэвхитэй үзлэг, 2.5 хувийг гэрийн дуудлагын үзлэг эзэлж байна.

Амбулаторийн үзлэгийн төрөл




Амбулаторийн үзлэг,
2021-2022 оны эхний 9 сарын байдлаар



ЖИРЭМСЭНИЙ ХЯНАЛТ

Шинээр хяналтанд авсан нийт 1726 жирэмсэн эмэгтэйчүүдээс 89.6 хувь нь жирэмсний эрт үедээ хяналтанд хамрагдсан байна. Цусны шинжилгээнд 93.5 хувь нь хамрагдаж, 1.2 хувь нь цус багатай гарсан байна. Эхний 9 сарын байдлаар жирэмсний хяналтанд шинээр орсон эхчүүдээс трихомониаз, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 93.4 хувийг, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 94.9 хувийг, ХДХВ илрүүлэх шинжилгээнд 94.3 хувийг тус тус хамруулж заг хүйтэн-49, трихомониаз-14, тэмбүү-28 тохиолдлыг тус тус бүртгэн эмчилсэн байна.



ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

2022 оны эхний 9 сарын байдлаар халдварт бус өвчлөл 83684 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 25210 тохиолдлоор буурсан байна. 10000 хүн амд 6115,3 байгаа ба осол гэмтлийн өвчлөл 1279 бүртгэгдэж, нийт халдварт бус өвчний 1,5 хувийг эзэлж, 10000 хүн амд 93,5 байна.

Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/




1. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин-1534.4
2. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 1298.9
3. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин- 1039.7
4. Нүд ба түүний дайврын тогтолцооны өвчин-502.6
5. Шээс бэлгэсийн тогтолцооны эмгэг-449.2


Стационарт нийт 22613 хүн хэвтэж эмчлүүлсэн ба дундаж ор хоног 6.8, орны эргэлт 23.7, орны фонд ашиглалт 160.9, фонд ашиглалтын хувь 65.0 байна. Алаг-Эрдэнэ, Арбулаг, Бүрэнтогтох, Тариалан, Тосонцэнгэл, Түнэл, Цагаан-Уул, Цагаан-Үүр, Цэцэрлэг сумд, Нэгдсэн эмнэлэг, хувийн эмнэлэг орны фонд ашиглалт аймгийн дунджаас дээгүүр, бусад газруудад доогуур хувьтай байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 9 сарын байдлаар нийт 15494 түргэн тусламжийн дуудлага хүлээж авч гүйцэтгэснээс 18,2 хувь /2821/ нь алсын дуудлага, 3,3 хувь /508/ нь осол гэмтлийн дуудлага байна. 1 өдөрт дунджаар аймгийн хэмжээнд 57,4 дуудлага, АНЭ 20,3 дуудлага тус тус хүлээн авч гүйцэтгэжээ.

ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны эхний 9 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 18093 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 20.7 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 40,0% эрэгтэй, 60.0% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 1872 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон артерийн гипертензи 614 буюу 32.8% нь онош баталгаажсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 17499 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 20.0 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 40,3% эрэгтэй, 59.7% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 457 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон 36 буюу 8,5% нь онош баталгаажсан байна.





ӨРХИЙН ЭМТ-ИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Өрхийн ЭМТ нийт үзлэг 56175 байгаа ба үзлэгийн төрлөөр нь авч үзвэл:

- Урьдчилан сэргийлэх үзлэг 30.7 хувь
- Өвчний учир үзлэг 38.2 хувь
- Диспансерийн хяналт 22.3 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 8.1 хувь
- Гэрийн дуудлага 0.7 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт бус өвчний 8965 тохиолдол бүртгэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 8.7 хувийг, 5 хүртэлх насны хүүхдийн халварт бус суулгалт 0.5 хувийг тус тус эзэлж байна.

Шинээр хяналтанд авсан 591 жирэмсэн эмэгтэйдгээс 87.0 хувийг эрт үед нь хяналтанд авч 100 хувийг цусны шинжилгээнд хамруулсан байна.

Нийт 164 нас баралт бүртгэгдсэн ба Аймгийн Нэгдсэн Эмнэлэгт 46 тохиолдол байна. Хорт хавдрын нас баралт 53, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 8 тохиолдол бүртгэгдсэнээс аймгийн нэгдсэн эмнэлэгт 6 тохиолдол бүртгэгдсэн байна.

ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хувийн эмнэлгүүд нийт 23691 үзлэг хийснээс

- Урьдчилан сэргийлэх үзлэг 2.4 хувь
- Диспансерийн хяналт 2,7 хувь
- Өвчний учир үзлэг 94.9 хувийг тус тус эзэлж байна.

Стационариар нийт 6396 хүн хэвтэн эмчлэгдэж, 47330 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.4 орны эргэлт 23.1 ба орны фонд ашиглалт 170.9, орны фонд ашиглалтын хувь 69.0 байна. Нийт 10 халдварт бус өвчний тохиолдол бүртгэгдсэн байна.

ХАЛДВАРТ ӨВЧИН


Аймгийн хэмжээнд эхний 9 сарын байдлаар 5252 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 383.8 ногдож байна. 2021 оны мөн үед 9699 тохиолдол, 10000 хүн амд 718.6 ногдож байжээ. 10000 хүн амд ногдох халдварт өвчний гаралт Цагаан-Үүр, Цэцэрлэг, Шинэ-Идэр, Мөрөн суманд аймгийн дунджаас өндөр байна.

Нийт халдварт өвчнөөс БЗХӨ 15.8 хувь, сүрьеэ 1.0 хувь, амьсгалын замын өвчин 0.9 хувь, цусан халдвар 0.1 хувь, гэдэсний халдварт өвчин 0.6, арьс салтстаар халдварлах халдвар 0.04, Зоонозын болон мал амьтнаас хүнд халдварладаг өвчлөл 0,3 хувь, Ковид-19 халдвар 81.3 хувийг тус тус эзэлж байна.

ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН

Нийт цочмог халдварт өвчний 4421 тохиолдлоос:


- Гар хөл амны өвчин 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Халдварын гаралтай суулгалт 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор
- Ёлом 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Гахай хавдар 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Цусан суулга 20 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 8 тохиолдлоор тус тус буурч
- Сальмонеллэз 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Сүрьеэ 51 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 10 тохиолдлоор
- Хоолны хордлого 6 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор
- Хепатит А 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хепатит В 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хепатит С 3 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Салхинцэцэг 47 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 30 тохиолдлоор
- Хачигт риккеттиоз 16 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 15 тохиолдлоор
- Ковид-19 4268 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 4870 тохиолдлоор тус тус өсч
- Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс халдварт саа, сахаруу, хөхүүл ханиад, татран, менингококкт халдварын өвчлөл бүртгэгдээгүй байна.



ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХАМ ШИНЖ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ

1. 2022 оны эхний 9 сарын байдлаар халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц 3658 тохиолдол мэдээлэгджээ. Үүнээс цэврүүт тууралт 30.3 хувь (47), цусархаг суулгалт 14.2 хувь (22), шарлалттай 5.8 хувь (9), халууралт тууралт 40.0 хувь (62), усархаг суулгалт 1.3 (2), хоолны хордлогот халдвар 8.4 хувь (13), тус тус бүртгэгдсэн байна.
2. Нийт мэдээлэгдсэн хам шинжийн өвчлөл /бодит тоогоор/


Халдварт өвчний хам шинж, сэжигтэй өвөрмөц тохиолдол, харъяалалаараа




ТОМУУ, ТОМУУ ТЕСТ ӨВЧИН

2022 оны эхний 9 сарын байдлаар аймгийн хэмжээнд ТТӨ-ийн 20659 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 1509.7 болсон байна. Харин өнгөрсөн оны мөн үед 7774 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 576.0 байжээ.


Томуу томуу тест өвчин, 10 000 хүн амд, 2022 он




Томуу томуу тест өвчин, долоо хоногоор



Томуу, томуу төст өвчин (насны бүлэг, хувиар), 2022 он



АЗЦХХ-ын хэвтэлт (насны бүлэг, хувиар), 2022 он




БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН



Нийт халдварт өвчний дотор БЗХӨ-ний эзлэх хувь 15.8% (831) тохиолдол байгаа ба өнгөрсөн оны мөн үед 4.7% (455) тохиолдол бүртгэгдсэнээс:

- Тэмбүү 120 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор ,
- Трихомониаз 53 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор тус тус буурч
- Гоноккокт халдвар 658 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 387 тохиолдлоор өссөн байна.

Бэлгийн замын халдварт өвчин, 2022 оны эхний 9 сарын байдлаар

■ тэмбүү ■ заг хүйтэн ■ трихомониоз





ЗӨВЛӨМЖ:

ЭТҮХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН Ш.АЛТАНТУЯА

Хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр:

Эхний 9 сарын байдлаар 0-5 насны хүүхдийн эндэгдэл 30 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор буурсан боловч улс, аймгийн дундаж үзүүлэлтэй өндөр байна. Нийт эндэгдлийн тохиолдлын 7 нь осол гэмтэл, 3 тохиолдол нь хатгалгаа өвчний улмаас эндэж байгаа нийт 12 тохиолдол буюу 40 хувь нь сэргийлж болох эндэгдэл байгаад анхаарлаа хандуулах хэрэгтэй байна. Хүүхдүүд эсэн мэнд амьдрах аюулгүй байдал нь алдагдаж, эрх нь зөрчигдөж, өсөлт, хөгжил, эрүүл мэндээрээ хохирч байгаа тохиолдол ч бүртгэгдэж байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нас барсан тохиолдолд газар дээр нь очиж үнэлгээ хийх болон маягтыг татаж авч үнэлгээ хийх, Эрүүл мэндийн газрын дэргэдэх “Тав хүртэлх насны хүүхдийн магадлан хэлэлцэх зөвөлийн хурал”-аасгарсан дүгнэлт шийдвэрийг харахад дараах үйл ажиллагаанд онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна.

Үүнд:

1. Эрүүл мэндийн байгууллагын иргэдэд үзүүлж байгаа тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, хүүхдэд ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлдэг болохын тулд Эрүүл мэндийн яамнаас зарласан “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах” нэрлэсэн жилийн хүрээнд алдаа дутагдал гарсан тохиолдол бүрийг бүртгэлжүүлэн тохиолдолд суурилсан хариу арга хэмжээ авах (ЭМС-ын 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/136 дугаар тушаал, 2019 оны А/566 дугаар).

2. Эмч, сувилагчийн бэлэн мэдлэг ур чадвар, тоног төхөөрөмжийн бэлэн байдалд тасралтгүй хяналтыг хяналтын хуудсаар, ижил мэргэжилтний эзлэгээр үнэлэх үйл ажиллагааг тогтмолжуулах. Ялангуяа Эрэмбэлэн ангилалт яаралтай тусламж, Уушигны хатгалгаа, суулгалт, олон нийтэнд түшиглэсэн болон эмнэлзүйн ХӨЦМ, осол гэмтлээс сэригйлэх сэдвээр эмнэл зүйн сургалтыг тодорхой давтамжтайгаар зохион байгуулж тусламж үйлчилгээний хожимдолоос сэргийлж ажиллах, яаралтай тусламж, амилуулах суурь тусламжийн мэдлэгийг дээшлүүлэх, дадлага сургалтыг 7 хоног бүр хийж хэвших /ЭМС-ын 2021 оны 814 дүгээр тушаал/

3. Эмчилгээ, оношилгооны стандарт, эмнэлзүйн удирдамж, түгээмэл үйлдлийн стандарт, эмнэлгийн журам, дүрэм нэг бүрийг чанд баримтлан ажиллах

4. Анхан шатны маягт хөтлөлтөөр ижил мэргэжилтний үнэлгээ хийж үр дүнг тооцон ажлын шалгуур үзүүлэлтэнд оруулж өгөх. (Эрүүл мэндийн сайдын 2019 оны 611 дүгээр тушаалын хавсралт иайгтууд: ХӨЦМ, ЭХЭМД, сувилахуйн түүх, жирэмсний хөтөч, өвчтөний түүх болон бусад бусад анхан шатны маягт)

5. Эмнэлэг хооронд тээвэрлэлт хийх шаардлагатай нэн хүнд эмгэгтэй хүүхэд бүрдээ хамтарсан үзлэг хийж, хамтын шийдвэр гаргах, нэн хүнд өвчтэй хүүхдийг эмнэлэг хооронд тээвэрлэхдээ заавал нарийн мэргэжлийн эмч нараас звлөгөө авч, хүүхдийн яаралтай тусламжийн багаар тээвэрлэх.

6. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг нийгмийн эрүүл мэндийн ажилтан ганцаараа хийхгүй бүх хүнийг хийдэг болгох. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлэх: хүүхэд хамгаалал, осол гэмтлээс сэргийлэх мэдлэгийг бага насны хүүхэдтэй өрх бүрт тогтмол өгч байх, сургалтын дараах үр дүнг тооцох. Үүнд: Бага насны хүүхдэд тохиолдох осол гэмтлээс сэргийлэх, осол гэмлтийн үед илрэх аюултай шинж тэмдэгийг таних, эмнэлгийн тусламж хайх талаарх зөв мэдлэгийг эцэг эх, асран хамгаалагч нарт тасралтгүй олгох, осол гэмтэл тохиолдсон үед үзүүлэх анхны тусламжийн мэдлэгтэй болгох.

7. Салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах. (Бүх байгууллагын нийгмийн ажилтнууд хамтарч үйл ажиллагааг зохион байгуулах, үр дүнг тооцох. Суманд ажилладаг хүүхдийн төлөө багууд, багийн засаг дарга, багийн эмч нарын ажлын уялдаа холбоог сайжруулах)

8. 0-17 насны хүүхдийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийг чанартай үнэн бодит байдлаар зохион байгуулах. 5 хүртэлх насны хүүхдэд сэтгэц, хөгжлийн үнэлгээг насны онцлогийг харгалзан асуумжийн аргаар хийж хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх нь чухал ба 0-5 насны хүүхдийн үзлэгийн мэдээ шивэлтийн байдал зөрөөтэй байгаад анхаарах. Үүнд. сар бүр авдаг 18,36 сартай хүүхдийн иж бүрэн үзлэгийн мэдээ цахим

прогаммын мэдээтэй зөрж байна. (0-5 нас, 6-17 насны хүүхдийн эрт илрүүлэгийн урьдчилан сэргийлэх үзлэг, 9,18, 36, 48, 60 сартай хүүхдийн эрүүл мэндийн иж бүрэн үзлэг Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаал)

9. Засаг даргын дэргэдэх эрүүл мэндийн салбар зөвлөл, ЭМТ-ийн чанарын багийн хурлыг дүрэм, журмын дагуу чанартай хийж оновчтой дүгнэлт шийдвэрийг гаргаж, үр дүнг тооцож байх.


10. Хүйтэн мэрүүний улирал эхэлж байгаатай холбоотой томуу томуу төст өвчин болон бусад халдварт өвчний үеийн тусламж үйлчилгээний тасралтгүй бэлэн байдлыг хангах.

НЭМТ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН Т.ХӨВСГӨЛ

2022 ОНЫ 3-Р УЛИРАЛЫН ГАДНЫ ШАЛТГААНТ ОСОЛ ГЭМТЛИЙН ӨВЧЛӨЛИЙН МЭДЭЭЛЭЛ ДҮГНЭЛТ ХИЙСЭН ЗӨВЛӨМЖ:

2022 оны эхний 9 сарын байдлаар осол гэмтлийн нас баралт 100 тохиолдол бүртгэгдсэн ба энэ нь 2021 оны 9 сарын байдалтай харьцуулахад 27 тохиолдолоор өссөн үзүүлэлттэй байна.

Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Бүрэнтогтох, Галт, Жаргалант, Их-Уул, Ренчинлхүмбэ, Тариалан, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Түнэл, Ханх, Цагаан-Уул, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Хатгал, Эрдэнэбулган сумдад нас баралтын тохиолдол их бүртгэгдсэн ба энэ Амиа хорлолт, Зам тээвэр, Хордлого, Усанд унаж живэх тохиолдонууд бүртгэгдсэн байна. Галт-3, Жаргалант-3, Хатгал-3 сумдад амиа хорлолтын тохиолдол давамгайлсан тул анхаарч ажиллах ба нийт эрүүл мэндийн байгууллагууд болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.



Гадны шалтгаант осол гэмтлийн өвчлөл 2021 оны 9 сарын байдлаар 717 тохиолдол бүртгэгдэж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч байсан бол 2022 оны 9 сарын байдлаар 1279 тохиолдол болж 562 тохиолдолоор огцом өссөн үзүүлэлттэй байна. Хатгал, Тосонцэнгэл, Цагаан-Уул сумдын өвчлөл бусад сумаас өндөр байгаа тул анхаарч ажиллах шаардлагатай байна. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлгээр 2021 оны 121 тохиолдол байсан бол 2022 оны 9 сарын байдлаар 616 осол гэмтлийн өвчлөл бүртгэгдэж огцом өссөн үзүүлэлттэй байна.



Иймд сумдад зонхилон тохиолдож буй зам тээвэр, бүх төрлийн уналт, амьгүй механик хүчин зүйлд өртөх, хүчирхийлэл зэрэг осол гэмтлийн тэргүүлэх эрсдэлээс сэргийлж мэдээлэл сургалт сурталчилгааг идэвхжүүлж ажиллах, өрхийн эрүүл мэндийн төвүүд иргэд рүү чиглэсэн сургалт сурталчилгааг салбар дундын байгууллагуудтай хамтран зохион байгуулах шаардлагатай тул дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

- Салбар дундын байгууллагуулын ажлыг эрчимжүүлж одоогийн нөхцөл байдлын талаар хуралдуулан тодорхой шийдвэр гаргах.
- Бүх сумд амиа хорлолтын чиглэлээр өөрийн орон нутагт тулгарч буй асуудлаар салбар дундын хурал зохион байгуулж шийдвэр гаргах
- Харьяа нутаг дэвсгэртэй эрсдэлийн үнэлгээг хийж хар цэгүүдийг тогтоох анхааруулах сэрэмжлүүлэх мэдээллийг бэлтгэж хүргэх
- Өвлийн улирал эхэлж байгаатай холбоотойгоор халтиргаа гулгаа, гол горхиноос болгоомжлох мэдээ мэдээллийг сургалтын хэлбэрээр болон цахим орчиноор дамжуулан иргэдэд хүргэх
- Өөрийн байгууллагын пайж хуудсанд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн цахим хуудас болон Эрүүл мэндийн газрын цахим хуудсанд байршуулсан мэдээллийг татан авч байршуулан иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулах.

НЭМТ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.МӨНХ-ЭРДЭНЭ

2022 ОНЫ 3-Р УЛИРАЛЫН ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЧИГЛЭЛЭЭР ЭРГЭН МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

- Аймгийн хэмжээнд 2022 оны гуравдугаар улиралын байдлаар Зонхилон тохиолдох халдварт бус өвчний 5 төрлийн эрт илрүүлэг үзлэгийн хамралтын дундаж-32% байгаа нь өмнөх оны мөн үеэс 28,6 %-аар буурсан байна. Артерийн даралт ихсэх өвчний илрүүлэг 20,3%, чихрийн шижин хэв шинж 2 өвчний илрүүлэг 19,7%, элэгний өмөнгийн илрүүлэг 18,9%, умайн хүзүүний өмөнгийн илрүүлэг 49,6%, хөхний өмөнгийн илрүүлэг 51,6%-тай байна.
- Артерийн даралт, Чихрийн шижин өвчний илрүүлэг үзлэгийн хамрагдалт нийт эрүүл мэндийн байгууллагууд хангалтгүй байна. Огт эхлүүлээгүй Ханх, маш хангалтгүй

Арбулаг, Баянзүрх, Галт, Их Уул, Рашаант, Тосонцэнгэл, Түнэл, Цагаан Уул, Цагаан Үүр, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төв, Далай-Элбэрэлт, Дэлгэрмөрөн өрхийн эрүүл мэндийн төвүүд байна.

- Элэгний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийг огт эхлүүлээгүй Алаг-Эрдэнэ, Арбулаг, Галт, Жаргалант, Ханх, Цэцэрлэг, маш хангалтгүй баянзүрх, Рашаант, Түнэл, Цагаан Уул, Цагаан Үүр, Чандмань-Өндөр, Хатгал, Цагааннуур, Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төв, Далай-Элбэрэлт, Дэлгэрмөрөн, Гурвангал өрхийн эрүүл мэндийн төвүүд байна.
- Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 49,5% буюу өмнөх оны мөн үеээс 0,3% буурсан. Цаашид Баянзүрх, Түнэл, Ханх сумын эрүүл мэндийн төв, Дэлгэрмөрөн, Энэрэл өрхийн эрүүл мэндийн төвүүд хамрагдалтын хувь, чанарыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийг нийт эрүүл мэндийн байгууллагууд жигд эхлүүлэн хамрагдалтыг тооцон ажиллаж байгаа боловч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9,8%-р тус тус буурсан байна. Цаашид Бүрэнтогтох, Ханх, Цагаан Уул эрүүл мэндийн төв, Гурвангал, Энэрэл өрхийн эрүүл мэндийн төвүүд хамрагдалтын хувь, чанарыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Зөвлөмж:

1. Аймгийн хэмжээнд жилийн эцсийн байдлаар эрт илрүүлэг үзлэгийн дундаж хамралтыг 80%-д хүргэх зорилт тавин ажиллаж байгаа тул эрүүл мэндийн байгууллагууд үлдсэн хугацаанд төлөвлөгөө гарган эрт илрүүлэг үзлэгүүдийг зохион байгуулах, программд шивэлтийг эрчимжүүл ажиллах.
2. Эрт илрүүлэг үзлэг зохион байгуулахтай холбогдуулан мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх.
3. МонПен санаачлагын хүрээнд артерийн даралт, чихрийн шижин, Зүрх судасны өвчлөлийн эрсдэлийн үнэлгээг хийх эрт илрүүлгийг эрчимжүүлэх, мэдээг тогтмол ирүүлж хэвших.

Хянасан:

Дүгнэлт хийсэн:

Эрүүл мэндийн газрын дарга М.Үүрийнбаяр

Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
П.Баярмаа